## ЭМГЭГ СУДЛАЛЫН ҮНДЭСНИЙ ТӨВ

# ЭХ ХҮҮХЭД, НӨХӨН ҮРЖИХҮЙН ЭРҮҮЛ МЭНД 2025-2028 ОНД ХЭРЭГЖИХ АРГА ХЭМЖЭЭНИЙ ТӨЛӨВЛӨГӨӨНИЙ БИЕЛЭЛТ

2026.06.10

| № | Үйл ажиллагаа | Суурь түвшн | Хүрэх үр дүн | Оролцогч талууд | | | Шаардагдах төсөв | Эх үүсвэр | Хэрэгжилт |
|---|---|---|---|---|---|---|---|---|---|
| | | 2024 он | 2026 он | Зохицуулах/ Хэрэгжүүлэх | Хамтрах | Шатлал | | | |
| Зорилт 2. Эх ураг, нярайн эрт үеийн тусламж, үйлчилгээнд нотолгоонд тулгуурласан үр дүнтэй үйл ажиллагааг эрчимжүүлэх, дэлхийн улс орнуудад нэвтрүүлж буй арга технологийг нутагшуулах, тусламж, үйлчилгээний байнгын бэлэн байдлыг хангах, төвлөрлийг сааруулж, хүртээмжийг нэмэгдүүлэн, чанарыг сайжруулж, эх, ураг, нярайн өвчлөл, эндэгдлийг бууруулах | | | | | | | | | |
| 2.8. | Нөхөн үржихүйн насны эмэгтэйчүүдийн эрхтэн тогтолцооны өвчин эмгэгийг эрт илрүүлэн эрүүлжүүлэх, жирэмслэлтэд бэлтгэх үйл ажиллагааг тогтмолжуулах, олон улсын байгууллагаас өгч буй зөвлөмжийн дагуу жирэмслэхээс өмнөх үзлэг шинжилгээний багцыг боловсруулж хэрэгжүүлэх | Эрт илрүүлэг үзлэгийн хамрагдалт 50% | Үзлэгт хамрагдвал зохиох эмэгтэйчүүдийн 50% хэмрэгдсэн байна. Илэрсэн өвчлөлийг эмчилсэн хувь 30% | Аймаг_ нийслэлийн ЭМГ, ӨЭМТ, СЭМТ | ЭМДЕГ, лавлагаа төвүүд, БОЭТ, АНЭ, АШУҮИС, хувийн хэвшилийн ЭМБ | Анхан шатны ЭМБ-ууд | 36000.0 | ЭМДаатгалын сан | Эмгэг судлалын үндэсний төв нь 2026 оны 06 дугаар сарын 10-ны өдрийн байдлаар нөхөн үржихүйн насны 1400 эмэгтэйчүүдийн эрхтэн тогтолцооны эмгэгийн амьд сорьцонд онош дүгнэлт өгч нөхөн үржихүйн насны эмэгтэйчүүдийн эрхтэн тогтолцооны өвчин эмгэгийг эрт илрүүлэх үйл ажиллагаанд оролцон ажиллаа. |
| 2.10. | Дутуу төрөлт, амьгүй төрөлтийн шалтгаан нөлөөлөх хүчин зүйлийг шуурхай тандан судалж, хариу арга хэмжээг эрчимжүүлэх, дутуу төрөлтийн менежментийн чиглэлээр эмч, мэргэжилтнийг багаар нь сургалтад хамруулах | | Тандалт судалгааны ажил хийгдсэн байна. Дутуу төрөлтийн менежментийн чиглэлээр эмч мэргэжилтний гадаа, дотоод сургалтад хамруулсан байна. | ЭМЯ-ны ЭТБГ, ЭХЭМҮТ, МСЗ, ЭМХТ | ЭНЭҮТ-2, амаржих газрууд, аймаг, нийслэлийн ЭМГ, БОЭТ, НЭ, АШУҮИС, хувийн хэвшлийн ЭМБ | Анхан болон лавлагаа шатлалын ЭМБ-ууд | 3100.0 | ДЭМБ, НҮБХАС, ЭМБ-ийн төсөв, ЭМДэмжих сан, ЭМДСан, Улсын төсвийн санхүүжилт | Дутуу төрөлт, амьгүй төрөлтийн шалтгаан нөлөөлөх хүчийн зүйлийг тандан судлах үйл ажиллагаанд тогтмол оролцон ажиллаж байна. Энэ оны эхний хагас жилийн байдлаар дутуу төрөлт, амьгүй төрөлтийн нийт 1648 ихэсийг шинжилж онош дүгнэлт өгч ажиллаа. |
| 2.22. | Эхийн эндэгдэл, ноцтой хүндрэлийн тохиолдлыг бүртгэж, мэдээлэхэд ДЭМБ-ын | Эрүүл мэндийн сайдын 2022 оны | Тушаалыг нягтлан шинжлэн боловсруулсан байна. АНЭ, | ЭМЯ-ны ЭТБГ ЭХЭММҮТ, ЭМХТ, МСЗ | ЭНЭҮТ-2 ЭМБ-ууд, НҮБХАС | Анхан болон лавлагаа | 56.0 | НҮБХАС | Энэ оны эхний хагас жилийн байдлаар Нийслэлийн Өргөө амаржих газар, Ховд БОЭТ, Завхан аймгийн нэгдсэн |

| | | | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|---|
| | шинэчлэгдсэн удирдамж, зааврын дагуу эхийн болон перинатал эндэгдлийн тандалт хариу арга хэмжээг эрчимжүүлэх | А/550 тоот тушаал | амаржих газрын чанар, сувилахуйн асуудал хариуцсан мэргэжилтнүүдийг сургалтад хамруулсан байна. | | | шатлалын ЭМБ-ууд | | | эмнэлэгт бүртгэгдсэн эхийн эндэгдлийн 3-н тохиолдолд эмгэг судлалын шинжилгээ хийж, нас баралтын шалтгаан, тусламж үйлчилгээний дутагдлыг тодорхойлон, онош дүгнэлт гаргасан. |
| Зорилт 3. Бага насны хүүхдэд үзүүлэх эрүүл мэндийн тусламж үйлчилгээнд нотолгоонд тулгуурласан үр дүнтэй үйл ажиллагааг нэвтрүүлэх, дэлхийн хөгжингүй улс орнуудад нэвтрүүлж буй шинэ арга технологийг нутагшуулах, хүүхдийн хоол тэжээл, хөгжлийг дэмжих, тусламж үйлчилгээний байнгын бэлэн байдлыг хангах, төвлөрлийг сааруулж, хүртээмжийг нэмэгдүүлэн, чанарыг сайжруулж, хүүхдийн сэргийлж болох өвчлөл эндэгдлийг бууруулах | | | | | | | | | |
| 3.13. | Хүүхдийн эрүүл мэндийн тусламж үйлчилгээнд нэн шаардлагатай эмнэлгийн тоног төхөөрмжийн шинэчлэл байнга хийгдэж, шинэ технологи нэвтрэхийн тулд эмч, эмнэлгийн мэргэжилтэн, инженер техникийн ажилтнуудыг сургалтад тогтмол хамруулж, чадавхжуулах ажлыг тасралтгүй зохион байгуулах | | Засвар үйлчилгээний болон шинээр худалдан авсан тоног төхөөрөмжийн санхүүжилт жил бүрийн төсөвт тодорхой тусгагдаж хэрэгждэг болсон байна. Шинээр нийлүүлж байгаа тоног төхөөрөмжийг ашиглах засварлах чиглэлээр инженер техникийн ажилтнууд сургагдсан байна | ЭМЯ-ны СЭЗБГ, ЭЭХЗГ, нийгэмлэг холбоод | МСЗ, Мэргэлжийн нийгэмлэг холбоод | Анхан болон лавлагаа шатлалын ЭМБ-ууд | 440.0 | Улсын төсөв | Хүүхдийн хортой болон хоргүй хавдрын 54 тохиолдолд иммуногистохимийн шинжилгээ хийж онош дүгнэлт өгсөн. Дээрх тоо мэдээ нь 2026 оны эхний хагас жилийн байдлаарх тоо мэдээ бөгөөд Эмгэг судлалын үндэсний төв иммуногистохимийн шинжилгээг үнэ төлбөргүй хийж эмгэг судлалын тусламж үйлчилгээг үзүүлж байна. |
| Зорилт 4. Өсвөр үеийнхэнд ээлтэй эрүүл мэндийн тусламж, үйлчилгээг тогтвортой үргэлжлүүлэн, чанар, хүртээмижйг сайжруулах, хүүхэд өсвөр үеийнхний хөгжлийг дэмжих | | | | | | | | | |
| 4.12. | Өсвөр үеийн жирэмслэлт, төрөлт, үр хөндөлтийн байдлыг судалж, хариу үйл ажиллагааг төлөвлөн хэрэгжүүлэх | | Үнэлгээ хийгдсэн байна | ЭХЭМҮТ, ЭНЭҮТ-2 | Аймаг, нийслэлийн ЭМГ | Анхан болон лавлагаа шатлалын ЭМБ-ууд | 450.0 | ЭМДэмжих сан, ОУБ | Өсвөр үеийн үр хөндөлтийн улмаас гэрээт эмнэлгүүдээс ирсэн умайн хөндийн хусмын 129 дээжид шинжилгээ хийж, онош дүгнэлт өгч ажилласан. |
| Зорилт 5. Эмэгтэйчүүд, хүүхэд, тусгай хэрэгцээтэй зорилтот бүлгийнхний өвөрмөц хэрэгцээнд нийцүүлэн нөхөн үржихүйн эрүүл мэндийн тусламж, үйлчилгээг тэгш хүртээмжтэй, чанартай үзүүлж, амьдарлын чанарыг сайжруулах | | | | | | | | | |

| | | | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|---|
| 5.2. | Эмэгтэйчүүдийн дотоод шүүрлийн эмгэг цэвэршилт, оношилгоо, эмчилгээний заавврыг шинэчлэн боловсруулж батлуулан хэрэгжүүлэх | | Зааврыг шинэчлэн боловсруулж, ЭМС-ын тушаалаар батлуулж, таниулан түгээсэн байна | ЭМЯ-ны НЭСБГ, МСЗ, ЭХЭМҮТ, АШУҮИС | ЭМДЕГ, ЭЭХЗГ, НҮБХАС, Мэргэжлийн нийгэмлэг холбоо | Анхан болон лавлагаа шатлалын ЭМБ-ууд | 60.0 | ЭМДэмжих сан, ОУБ, Байгууллагын төсөв | Цэвэршилтийн насны эмэгтэйчүүдийн хэвийн бус цус алдалтын улмаас ирсэн 320 дээжинд шинжилгээ хийж, онош дүгнэлт өгсөн. |
| 5.4 | Үр хөврөл судлаач, техникийн мэргэжилтэн, урогиметолог, ихсийн патогистологич чиглэлээр эмч, эмнэлгийн мэргэжилтнүүдийг сургаж бэлтгэх | | ЭХЭМҮТ, ЭНЭҮТ, БОЭТ-ийн эмч мэргэжилтнүүдийг багаар сургаж бэлтгэсэн байна | ЭХЭМҮТ, ЭНЭҮТ, ЭМХТ, БОЭТ | Аймаг нийслэлийн ЭМГ, АШУҮИС, Мэргэжлийн нийгэмлэг холбоо | лавлагаа шатлалын ЭМБ-ууд | 750.0 | Улсын төсөв, Байгууллагын төсөв, Хамтрагч улс орны дэмжлэг | Ихэсийн эмгэг судлалын оношилгооны талаар анатомийн эмгэг судлал, шүүх эмнэлэг, эх барих эмэгтэйчүүдийн үндсэн мэргэжлийн резидент эмч нарт тогтмол сургалт зохион байгуулан ажилладаг бөгөөд 2026 оны 06 дугаар сарын 10-ны өдрийн байдлаар 120 резидент эмчийг сургалтад хамруулсан. |